



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/18/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261205 Цахим хаяг: Khosjargalts@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Эс Жи Эм Ди- Аудит ХХК-ийн захирал: Д.Эхбаяр
Утас: 99116948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АГУУЛГА

1.Хараат бус аудиторын дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
СНАГ	Санхүү-Нийцлийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл



УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВИЙН
ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Б.БЯМБАДОРЖ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/364

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлангийн иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Худалдан авалтыг зохион байгуулахдаа босго үнийг баримтлалгүй хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материал, сэлбэг хэрэгсэл зэрэг нийт 309,958.5 мянган төгрөгийн барааг шууд худалдан авсан;
- Бараа материалын үлдэгдэлд 69,208.0 мянган төгрөгийн өртөг өндөртэй эм, эмнэлгийн хэрэгслийг их хэмжээгээр нөөцөлсөн, тухайлбал 2023 оны 3 дугаар сард хугацаа нь дууссан 24000 ширхэг "Натри хлорид 0.9%-10мл" уусмалыг Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс авсан;

зэрэг зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Засгийн газрын 2021 оны 24 дүгээр тогтоол, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, 16.5.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаар тушаалаар баталсан "Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам" тай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сангаас нэн шаардлагатай тусламж үйлчилгээг санхүүжүүлж эхэлснээр эдгээр тусламж үйлчилгээг үзүүлэгч тус байгууллагын тусламж үйлчилгээний төрөл нэмэгдэж, санхүүгийн эрсдэл, эмнэлгийн санхүүгийн менежмент сайжрах, байгууллагын хөрөнгө оруулалт, эмч эмнэлгийн ажилчдын цалин хөлс, нийгмийн хамгаалал, орчин нөхцөлийг сайжруулах боломж бүрдсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/134, А/479, А/519 дүгээр тушаалуудаар 655,459.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурыг шилжүүлж өгснийг эмнэлгийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/146 тоот тушаалаар хугацаа дуусах дөхсөн гэсэн шалтгаанаар актлах тушаал гаргасан ба тухайн эм, эмнэлгийн хэрэгслийг устгаагүй байна

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,900,696,196.96	13,411,440,664.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	237,694,794.16	61,472,285.12
312	Банканд байгаа бэлэн мөнгө	237,628,944.16	53,177,314.12
3121	Төгрөг	237,628,944.16	53,177,314.12
31211	Төрийн сангийн харилцах	234,646,473.16	53,167,314.12
31213	Арилжааны банк дахь харилцах	2,982,471.00	10,000.00
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	65,850.00	8,294,971.00
33	АВЛАГА	89,028,833.48	4,320,077,877.06
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	953,478.00	1,723,445.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	4,247,773,198.05
335	Бусад авлага	88,075,355.48	70,581,234.01
3351	Байгууллагаас авах авлага	71,140,399.00	53,718,974.13
3352	Хувь хүмүүсээс авах авлага	16,934,956.48	16,862,259.88
34	УРЬДЧИЛГАА	-	6,267,983.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	6,267,983.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	6,267,983.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,573,972,569.32	9,023,622,519.58
351	Түүхий эд материал	3,449,381,123.64	3,562,671,976.00
35110	Тусгай зориулалттай материал	86,840,320.00	73,837,381.00
35130	Эм боох материал	3,362,540,803.64	3,488,834,595.00
354	Хангамжийн материал	5,124,591,445.68	5,460,950,543.58
35410	Бичиг хэргийн материал	13,177,160.00	55,457,001.59
35420	Аж ахуйн материал	136,181,278.96	154,771,470.40
35430	Сэлбэг хэрэгсэл	25,762,209.00	32,814,040.00
35440	Түлш, шатах тослох материал	5,716,692.00	5,947,710.07
35450	Барилгын засварын материал	28,240,678.83	10,924,410.00
35460	Хүнсний материал	41,613,824.00	17,718,087.00
35470	Бусад хангамжийн материал	4,873,899,602.89	5,183,317,824.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	60,544,289,469.31	52,094,885,028.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	60,544,289,469.31	52,094,885,028.35
392	Биет хөрөнгө	58,292,168,172.98	50,216,979,770.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,704,000,658.35	9,037,742,658.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,355,669,707.41)	(2,986,740,989.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	544,192,893.00	544,192,893.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(227,318,826.59)	(279,149,731.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,901,163,226.74	84,961,868,387.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,868,678,238.92)	(43,016,424,860.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,062,743,335.16	5,256,614,333.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,145,717,537.91)	(3,837,571,067.67)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,179,540,630.00	1,179,540,630.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(502,088,259.44)	(643,092,482.54)
393	Биет бус хөрөнгө	2,252,121,296.33	1,877,905,258.03
39301	Программ хангамж	1,742,847,883.00	1,742,847,883.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(995,651,846.67)	(1,369,867,884.97)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,504,925,260.00	1,504,925,260.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	69,444,985,666.27	65,506,325,693.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	965,361,168.41	7,558,106,038.53
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	965,361,168.41	7,558,106,038.53
413	Өглөг	750,332,068.41	7,539,579,138.53
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,252,239.41	542,387.31

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	747,441,480.00	7,017,122,575.22
4136	Бусад өглөг	1,638,349.00	521,914,176.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,534,400.00	520,954,840.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	103,949.00	959,336.00
414	Урьдчилж орсон орлого	215,029,100.00	18,526,900.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	12,149,000.00	14,705,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	202,880,100.00	3,821,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	68,479,624,497.86	57,948,219,654.58
51	Засгийн газрын хувь оролцоо	68,479,624,497.86	57,948,219,654.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,941,287,076.42	11,941,287,076.42
51101	Өмч:- төрийн	11,941,287,076.42	11,941,287,076.42
512	Хуримтлагдсан үр дүн	51,566,547,188.88	41,035,142,345.60
51210	Өмнөх үеийн үр дүн	49,485,737,637.64	51,570,728,116.38
51220	Тайлант үеийн үр дүн	2,080,809,551.24	(10,535,585,770.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,971,790,232.56	4,971,790,232.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	69,444,985,666.27	65,506,325,693.11

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	46,971,035,945.39	46,328,559,122.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,321,059,595.02	9,962,258,538.92
120	Нийтлэг татварын бус орлого	3,693,980,329.90	6,202,289,527.59
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,616,083,529.90	5,908,127,443.03
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,108,146,415.68	3,477,039,552.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	196,342,914.22	2,431,087,891.01
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	311,594,200.00	-
120005	Түрээсийн орлого	77,896,800.00	171,434,400.00
120009	Бусад орлого	-	122,724,684.56
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,104,103,340.30	3,213,398,297.77
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,522,975,924.82	546,573,713.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,649,976,350.37	36,366,300,583.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,417,207,106.87	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,417,207,106.87	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	32,232,769,243.50	36,366,300,583.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,232,769,243.50	36,366,300,583.30
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	44,889,045,066.16	56,864,144,893.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44,889,045,066.16	56,864,144,893.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,639,605,902.16	56,657,083,985.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,140,555,866.24	15,641,340,667.01
210101	Үндсэн цалин	5,393,266,059.24	8,165,107,068.01
210102	Нэмэгдэл	3,445,539,496.00	5,490,117,715.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	552,671,000.00	856,453,851.00
210104	Урамшуулал	749,079,311.00	1,129,962,033.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,291,985,131.7	1,990,077,432.16
210201	Тэтгэврийн даатгал	1,237,930,180.75	1,757,602,695.31
210205	Эрүүл мэндийн даатгал	54,054,951.00	232,474,736.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,278,687,397.34	1,633,844,641.65
210301	Гэрэл, цахилгаан	701,182,517.00	936,139,418.71
210302	Түлш, халаалт	234,480,638.34	300,507,542.95
210303	Цэвэр, бохир ус	343,024,242.00	397,197,679.99
2104	Хангамж, бараа материалын зардал	723,769,500.78	1,023,675,930.62
210401	Бичиг хэрэг	97,834,909.00	130,743,968.41
210402	Тээвэр, шатахуун	38,675,950.00	75,630,622.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,704,682.45	23,219,409.86
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	283,033,335.16	393,793,298.81
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	284,520,624.17	400,288,631.54
2105	Норматив зардал	17,868,599,938.44	21,335,684,309.67
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,443,936,066.00	20,694,008,077.50
210502	Хоол, хүнс	375,701,311.44	466,935,186.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	48,962,561.00	174,741,046.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	268,933,005.67	1,138,834,742.21
210604	Урсгал засвар	268,933,005.67	1,138,834,742.21
2107	Томилолт, зочны зардал	12,400,000.00	127,492,800.00
210701	Гадаад албан томилолт	-	1,100,000.00
210702	Дотоод албан томилолт	12,400,000.00	126,392,800.00

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146,444,463.00	323,519,951.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,933,286.00	239,840,237.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	792,990.00	979,020.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	692,120.00	807,848.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	209,000.00	264,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,243,852.00	45,778,100.00
210807	Газрын төлбөр	11,513,972.00	23,796,622.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	59,243.00	54,123.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,908,230,598.94	13,442,613,510.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,084,721.00	155,466,703.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,167,722,452.00	1,041,452,904.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,696,423,425.94	12,245,693,903.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	249,439,164.00	207,060,908.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	249,439,164.00	207,060,908.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	172,958,868.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	249,439,164.00	34,102,040.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,081,990,879.23	(10,535,585,770.78)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,181,327.99	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,181,327.99	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,181,327.99)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,080,809,551.24	(10,535,585,770.78)

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	39,778,930,770.02	37,912,457,740.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,591,109,921.65	37,912,457,740.39
120	Нийтлэг татварын бус орлого	3,591,109,921.65	5,790,966,655.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,591,109,921.65	5,790,966,655.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,007,451,787.97	3,367,704,633.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,920,766,329.55	2,418,005,372.12
120009	Бусад орлого	80,000.00	5,256,650.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	271,069,200.00	-
122	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,608,377,206.87	32,121,491,085.25
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	34,579,443,641.50	32,121,491,085.25
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,579,443,641.50	32,121,491,085.25
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	39,592,260,657.67	37,865,268,949.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,592,260,657.67	37,865,268,949.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,357,323,694.67	37,657,838,041.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,188,020,792.92	16,566,755,527.00
210101	Үндсэн цалин	6,601,549,485.41	9,268,534,408.00
210102	Нэмэгдэл	3,288,024,140.51	5,320,927,119.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	552,239,531.00	847,331,000.00
210104	Урамшуулал	746,207,636.00	1,129,963,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,424,113,050.87	2,098,647,669.00
210201	Тэтгэврийн даатгал	990,881,598.21	1,440,693,640.00
210202	Тэтгэмжийн даатгал	111,566,080.32	169,984,772.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	86,935,461.41	133,370,560.00
210204	Ажилгүйдлийн даатгал	21,241,945.67	32,070,420.00
210205	Эрүүл мэндийн даатгал	213,487,965.26	322,528,277.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,278,687,397.34	1,633,844,641.65
210301	Гэрэл, цахилгаан	701,182,517.00	930,496,682.96
210302	Түлш, халаалт	234,480,638.34	302,314,366.69
210303	Цэвэр, бохир ус	343,024,242.00	401,033,592.00
2104	Хангамж, бараа материалын зардал	338,881,504.68	449,255,128.86
210401	Бичиг хэрэг	47,820,259.00	110,401,390.00
210402	Тээвэр, шатахуун	40,459,000.00	65,237,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,759,482.68	20,252,109.86
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,208,875.00	227,028,249.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,633,888.00	26,335,580.00
2105	Норматив зардал	23,817,179,226.74	15,299,156,252.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,016,367,570.74	14,323,839,919.42
210502	Хоол, хүнс	569,350,656.00	647,539,851.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	231,461,000.00	327,776,482.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	625,116,145.00	966,285,236.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	306,286,756.00	84,663,170.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	27,549,000.00
210604	Урсгал засвар	318,829,389.00	854,073,066.50
2107	Томилолт, зочны зардал	30,000,000.00	127,706,700.00
210702	Дотоод албан томилолт	30,000,000.00	127,706,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,746,525.12	379,604,881.00

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	505,042,470.35	271,113,928.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,900,000.00	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	666,920.00	979,020.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	692,120.00	807,848.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	209,000.00	264,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,378,949.77	37,350,000.00
210807	Газрын төлбөр	11,513,972.00	23,796,622.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	59,243.00	54,123.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	35,283,850.00	33,239,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,579,052.00	136,582,005.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,706,552.00	136,582,005.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	872,500.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234,936,963.00	207,430,908.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	234,936,963.00	207,430,908.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	221,579,200.00	172,958,868.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,357,763.00	34,472,040.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	186,670,112.35	47,188,790.96
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	223,411,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	223,411,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	223,411,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	223,411,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(223,411,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	186,670,112.35	(176,222,509.04)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,024,681.81	237,694,794.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	237,694,794.16	61,472,285.12

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	49,597,683,332.64	66,510,760,641.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(111,945,695.00)	(111,945,695.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	49,485,737,637.64	66,398,814,946.62
7	Тайлант үеийн үр дүн	-	-	2,080,809,551.24	2,080,809,551.24
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	51,566,547,188.88	68,479,624,497.86
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,180,927.50	4,180,927.50
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	51,570,728,116.38	68,483,805,425.36
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,535,585,770.78)	(10,535,585,770.78)
17	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	41,035,142,345.60	57,948,219,654.58

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,889,305,100.00	38,088,680,249.43	5,800,624,850.57	86.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,889,305,100.00	38,088,680,249.43	5,800,624,850.57	86.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,299,948,100.00	37,881,249,341.43	5,418,698,758.57	87.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,686,187,900.00	16,566,755,527.00	119,432,373.00	99.3
210101	Үндсэн цалин	9,391,419,900.00	9,268,534,408.00	122,885,492.00	98.7
210102	Нэмэгдэл	5,320,145,400.00	5,320,927,119.00	(782,119.00)	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	846,260,000.00	847,331,000.00	(1,071,000.00)	100.1
210104	Урамшуулал	1,128,363,000.00	1,129,963,000.00	(1,600,000.00)	100.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,112,943,000.00	2,098,647,669.00	14,295,331.00	99.3
210201	Тэтгэврийн даатгал	1,451,996,100.00	1,440,693,640.00	11,302,460.00	99.2
210202	Тэтгэмжийн даатгал	165,236,700.00	169,984,772.00	(4,748,072.00)	102.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	132,189,400.00	133,370,560.00	(1,181,160.00)	100.8
210204	Ажилгүйдлийн даатгал	33,047,300.00	32,070,420.00	976,880.00	97.0
210205	Эрүүл мэндийн даатгал	330,473,500.00	322,528,277.00	7,945,223.00	97.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,634,320,000.00	1,633,844,641.65	475,358.35	99.9
210301	Гэрэл, цахилгаан	915,000,000.00	930,496,682.96	(15,496,682.96)	101.7
210302	Түлш, халаалт	350,000,000.00	302,314,366.69	47,685,633.31	84.4
210303	Цэвэр, бохир ус	369,320,000.00	401,033,592.00	(31,713,592.00)	108.6
2104	Хангамж, бараа материалын зардал	543,443,300.00	450,155,128.86	93,288,171.14	82.8
210401	Бичиг хэрэг	126,154,000.00	110,401,390.00	15,752,610.00	87.5
210402	Тээвэр, шатахуун	83,129,500.00	65,237,800.00	(17,891,700.00)	78.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,280,000.00	20,252,109.86	27,890.14	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270,860,400.00	227,028,249.00	43,832,151.00	83.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,019,400.00	27,235,580.00	15,783,820.00	63.3
2105	Норматив зардал	20,178,740,000.00	15,299,156,252.42	4,879,583,747.58	75.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,192,000,000.00	14,323,839,919.42	4,868,160,080.58	74.6
210502	Хоол, хүнс	658,940,000.00	647,539,851.00	11,400,149.00	98.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	327,800,000.00	327,776,482.00	23,518.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,466,383,800.00	1,188,796,536.50	(277,587,263.50)	81.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	434,942,200.00	307,174,470.00	127,767,730.00	70.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	27,549,000.00	27,549,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,003,892,600.00	854,073,066.50	149,819,533.50	85.1
2107	Томилолт, зочны зардал	124,640,000.00	127,706,700.00	(3,066,700.00)	102.5
210702	Дотоод албан томилолт	124,640,000.00	127,706,700.00	(3,066,700.00)	102.5

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	412,420,600.00	379,604,881.00	32,815,719.00	92.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	283,500,000.00	271,113,928.00	12,386,072.00	95.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,614,500.00	12,000,000.00	3,614,500.00	76.9
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,100.00	979,020.00	21,080.00	97.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,100,000.00	807,848.00	292,152.00	73.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	350,000.00	264,000.00	86,000.00	75.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,350,000.00	37,350,000.00	(4,000,000.00)	112.0
210807	Газрын төлбөр	29,259,000.00	23,796,622.00	5,462,378.00	81.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,420,000.00	54,123.00	4,365,877.00	1.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	43,827,000.00	33,239,340.00	10,587,660.00	75.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,869,500.00	136,582,005.00	(4,287,495.00)	97.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,869,500.00	136,582,005.00	(4,287,495.00)	97.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	589,357,000.00	207,430,908.00	381,926,092.00	35.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	589,357,000.00	207,430,908.00	381,926,092.00	35.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	541,357,000.00	172,958,868.00	368,398,132.00	32.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,000,000.00	34,472,040.00	13,527,960.00	71.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,889,305,100.00	37,912,457,740.39	5,976,847,359.61	86.4
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	36,565,797,200.00	32,121,491,085.25	4,444,306,114.75	87.8
134002	Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих	36,565,797,200.00	32,121,491,085.25	4,444,306,114.75	87.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	7,323,507,900.00	5,790,966,655.14	1,532,541,244.86	79.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,712,000,100.00	3,371,775,804.02	340,224,295.98	90.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,376,861,300.00	2,419,190,851.12	957,670,448.88	71.6
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	234,646,500.00			
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		237,694,794.16		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		61,472,285.12		
	Байгууллагын мэдээлэл	1	1	-	100.0
	Байгууллагын мэдээлэл	1	1	-	100.0
	АЖИЛЛАГСДЫН ТОО	566	560	6	98.9
	Удирдах	4	4	-	100.0
	Гүйцэтгэх	416	412	4	99.0
	Үйлчлэх	146	144	2	98.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь эрхэм зорилгоо “ард иргэдийн хүсэл хэрэгцээг хангахуйц, чанартай аюулгүй тусламж үйлчилгээтэй шилдэг эмнэлэг байна” гэж тодорхойлсон байна.

Тайлант оны онцлох үйл явдлуудыг дурдвал:

- ✓ ПЕТ/КТ оношилгоонд ашиглах цацраг идэвхэд эмийн нэр төрлийг нэмэгдүүлсэн;
- ✓ Тайлант онд өвдөгний үе солих 185, түнхний үе бүтэн солих 18, түнхний үе хагас солих 9 хагалгаа, өвдөгний үений дурангийн 21 хагалгаа хийгдсэн;
- ✓ Дуудлагын төвтэй болсноор 70150222 дугаарын утсаар нийт 28764 үйлчлүүлэгчид үзлэгийн цаг авах, мэдээлэл өгөх зэрэг үйлчилгээ үзүүлсэн байна. Нийт 3685 үйлчлүүлэгчид E-mail хаягаар шинжилгээний хариу илгээсэн байна. E-Mongolia системээр цаг захиалах модулийн шинэчлэгдсэн хөгжүүлэлтийг хийсэн;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Тухайлбал:

- Төрийн хэмнэлийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 49, А/118 дугаар тушаал “төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” тушаал;
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2023 оны 240, 241 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол;
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 49, А/118 дугаар “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” тушаал;
- ЭМДҮЗ-ийн 05 дугаар “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- ЭМДҮЗ-ийн 08 дугаар “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоол.
- ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2017 оноос хойш шинэчлэн боловсруулаагүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, гүйцэтгэлээр санхүүжигдэхтэй холбоотой орлого хүлээн зөвшөөрөлт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэх гэх мэт санхүүгийн удирдлагын өөрчлөлт, онцлогтой өөрчлөлтүүдийг тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,938,660.0 мянган төгрөг буюу 5,67 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	237,694.8	61,472.3	(176,222.5)
Авлага	89,028.8	4,320,077.9	4,231,049.1
Урьдчилгаа	-	6,268.0	6,268.0
Бараа материал	8,573,972.6	9,023,622.5	499,649.6
Үндсэн хөрөнгө	60,544,289.5	52,094,885.0	(8,449,409.5)
Нийт хөрөнгө	69,444,985.7	65,506,325.7	(3,938,660.0)
Өр төлбөр	965,361.2	7,558,106.0	6,592,744.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	68,479,624.5	57,948,219.6	(10,531,404.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	69,444,985.7	65,506,325.7	(3,938,660.0)

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэл 61,472.3 мянган төгрөг болж 176,222.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд ЭМДС-аас авах төлбөртэй үйлчилгээний орлого бүрэн гүйцэт орж ирээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд эрүүл мэндийн даатгалын сангаас авах төлбөртэй үйлчилгээний авлага 4,247,733.2 мянган төгрөг, барилга, лифтийн засвар, хэвлэлт, төслийн ажлын гүйцэтгэлтэй холбоотой байгууллагаас авах авлага 52,030.6 мянган төгрөг, эм ханган нийлүүлэх байгууллагаас авах 1,688.3 мянган төгрөг, ажиллагсдаас авах 1,723.4 мянган төгрөг, хувь хүнээс авах авлага 16,862.3 мянган төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Бараа материал данс худалдан авсан 23,986,938.2 мянган төгрөг, ЭМЯ-аас үнэ төлбөргүй хуваарилсан 232,864.9 мянган төгрөг, ХӨСҮТ-өөс үнэ төлбөргүй шилжүүлсэн 187,658.1 мянган төгрөг, бусад байгууллагуудаас үнэ төлбөргүй авсан 125,197.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 23,175,117.5 мянган төгрөг, эвдэрч ашиглах боломжгүй болсон

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл, Ерөнхий захирлын 2023 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн А/49 болон А/146 дугаар тушаалуудаар акталсан хангамж, бараа материал 907,891.5 мянган төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Бараа материалын үлдэгдэлд өндөр өртөгт хагалгааны зориулалттай 1,891,676.8 мянган төгрөг, эмчилгээ зориулалттай 1,596,471.0 мянган төгрөг, ариутгал халдваргүйжүүлэлтийн 686,745.8 мянган төгрөгийн зэрэг нийт 3,488,837.6 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөц байна. Үүнээс 49,256.1 мянган төгрөгийн үнэ бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн ашиглалтын хугацаа дууссан байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд худалдан авсан 223,411.3 мянган төгрөг, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн дүн 3,213,398.3 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2023 оны 254 дүгээр тогтоолын дагуу үнэ шинэчлэн тогтоосон 122,724.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг данс бүртгэлээс хассан 85,600.0 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд эм ханган нийлүүлэх байгууллагад өгөх өглөг 7,538,077.4 мянган төгрөг, хувь хүмүүст өгөх өглөг 959.3 мянган төгрөг, ажиллагсадтай холбогдсон өглөг 542.4 мянган төгрөг, урьдчилж орсон орлого 18,529.9 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 10,531,404.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн болон 4,180.9 мянган төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг залруулсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын алдаанаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 39,089,770.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,474,860.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 352,732.8 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт орлого, зарлагыг 43,917,364.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг хянан, бараа үйлчилгээний зардлыг 584,628.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 44,501,992.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны жилийн эцэст Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

Тодотголоор батлагдсан төсвийг 612,687.0 мянган төгрөгөөр бууруулж тодотгожээ.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 36,565,797.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 7,088,861.4 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос бүрдүүлж, өмнөх оны үлдэгдлээс 234,646.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 32,121,491.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5,790,966.7 мянган төгрөг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 38,088,680.2 мянган төгрөг буюу 86.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 133,727.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 93,288.2 мянган төгрөг, норматив зардлыг 4,879,583.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний, төлбөр хураамжийн зардлыг 32,815.7 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 381,926.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	43,889,305.1	38,088,680.2	6,377,750.6	86.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	43,299,948.1	37,881,349.3	5,418,698.8	87.5
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшуулал	589,357.0	207,430.9	381,926.1	35.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 32,337,343.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 17 бараа, ажил, үйлчилгээг, үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 12, харьцуулалтын аргаар 5 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж баталсан байна.

Гүйцэтгэлээр ХАА-ны төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтаар 29,815,652.2 мянган төгрөг, цахим дэлгүүрээс ерөнхий гэрээгээр 1,085.459.6 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитыг Эс Жи Эм Ди-Аудит ХХК-ийн ахлах аудитор О.Алтанцэцэг, аудитор О.Ганчимэг, аудитын шинжээч Ч.Ням-Очир нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Б.Оюунцэцэг, аудитын менежер Д.Насанжаргал, захирал Д.Эхбаяр нар хяналтыг хэрэгжүүлсэн.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 7/46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 44,889,045.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 448,890.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэн бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх, байгууллаас зохион байгуулах сургалт, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд дуудлагын тээврийн хэрэгсэл ашигладаггүй, тэргүүн дэд, орлогч дарга, зөвлөхийн орон тоо байхгүй, цахим дэлгүүрээс 28,542.0 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 5,676,402.9 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 287 зардлын гүйлгээний 9,296,918.4 мянган төгрөгийн мэдээлэл байршуулахаас 1,131,607.0 мянган төгрөгийн зарлагын 10 гүйлгээ, худалдан авах ажиллагааны өөрчлөлт орсон төлөвлөгөө зэргийг мэдээлээгүй, мөн шилэн дансны "хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн мэдээлэл" хэсэгт мэдээлэгдэх зарим тендерүүдийн мэдээллийг мэдээлээгүй байна. Тухайлбал: Санчир ундрах ХХК (Багц 44,45,47,48,57,62,67) гэрээний нийт дүн 1,499,040.0

мянган төгрөг, Чоно гол ХХК (Багц 23,39,40,46,49,50,51,52,65,66) гэрээний нийт дүн 1,499,910.5 мянган төгрөг байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалт болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр 3.2.8 "хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь мэдээлээгүй зөрчил давтагдсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй албан шаардлага хүргүүлэх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1.Тайлант онд 1,113,094.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг шууд худалдан авах гэрээ байгуулж худалдан авсан, гэрээг тасаг нэгжийн ажилтнууд бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулдаг ба гэрээ дүгнэсэн акт байхгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.", 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах гэрээг тасаг, нэгжийн ажилтнууд бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай хийсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерт оролцогч байгууллагын зүгээс ирүүлсэн бараа бүтээгдэхүүний дээжийг холбогдох тасаг, нэгжээр чанарын хяналт хийлгүүлэн авсан дүгнэлтийг гарын үсгээр баталгаажуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 "үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах", Сангийн сайдын 2021.06.30-ны өдрийн 103 дугаар тушаалын 3.2-т "Үнэлгээний хороонд томилогдсон гишүүн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан эрх эдэлж үүрэг хүлээх ба худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, аргачлал, зааврыг дагаж мөрдөнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа бүтээгдэхүүний дээжийг холбогдох тасаг, нэгжээр чанарын хяналт хийлгүүлэн авсан дүгнэлтийг гарын үсгээр баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

3. Тайлант онд зохион байгуулсан 149,950 мянган төгрөгийн өртөгтэй харуул хамгаалалтын үйлчилгээ болон 145,037.7 мянган төгрөгийн нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг тусгасан боловч шалгарсан ТДЕ ХХК, Өлзийтхан ХХК-аас гүйцэтгэлийн баталгаа авахгүйгээр байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4 "Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана.", 43.4.2. "100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах," гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн баримт бичигт заасны дагуу сонгон шалгарсан бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

шалгуурт нийцээгүй, ТБОНӨХБАҮХАТХ-ийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгадагч байгууллагын 2023 оны 2 улирлын санхүүгийн тайланг хамруулж, 8 үндсэн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн. Аудитаар 16,112,220.7 мянган төгрөгийн 15 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 10,435,818.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгасан байна. Биелэлт хангалтгүй 5,676,402.4 мянган төгрөгийн 5 зөрчлийг тайлант оны аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар хариуцлага тооцуулах 9,293,115.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг арилгах 7,616,626.6 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 156,500.0 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хариуцлага тооцуулах албан шаардлага	1	9,293,115.4	-	-	0.0
Албан шаардлага	3	7,616,626.6	3	7,616,626.6	100.0
Зөвлөмж	5	156,500.0	1	156,500.0	100.0
Дүн	10	17,088,058.1	4	7,773,126.6	30.0

Өмнөх оны аудитаар өгсөн хэрэгжилт хангалтгүй дараах зөвлөмж, албан шаардлагууд байна. Үүнд:

- Тайлант оны аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгахад хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчил давтагдсан тул албан шаардлага хүргүүлэх;
- Дотоод хяналтыг хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдсан тул албан шаардлага хүргүүлэх;
- ЭМЯ-ны салбар зөвлөлтэй хамтарч ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэх;
- Худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах хуулийн байгууллагад шилжүүлэх албан шаардлагын биелэлт хангалтгүй байгаа тул дээд шатны захирагчид сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрт нэхэмжилсэн санхүүжилт бүрэн олгогдохгүй байгаагаас эмнэлгийн санхүү, эдийн засгийн үзүүлэлт буурах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөхөөр байгаа зэргийг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64,863,179.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн өмнөх оны цэвэр хөрөнгө өмчийн дүн 68,479,624.5 мянган төгрөг байхад Өмчийн өөрчлөлтийн тайланд 133,021,521.3 мянган төгрөгөөр буюу 64,541,896.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь УСНББОУС-1-ийн 102-т "Санхүүгийн тайлан дахь үзүүлэлтүүдийн толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгална." заалт, санхүүгийн тайлагналын иж бүрэн, бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Санхүүгийн байдлын тайлангийн тусгай зориулалттай материал дансны тайлант оны 73,837.4 мянган төгрөгийн үлдэгдлийг бараа материалын тайлангийн 395,120.0 мянган төгрөгийн үлдэгдлээс 321,262.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1,198,097.8 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 975,417.6 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 222,680.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Үүнээс санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

1. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд тус эмнэлгийн хамт олны төлөөлөх 3 гишүүнийг Ерөнхий захирлын 2021 оны 8 дугаар сарын 12-ны А/100 тоот тушаалаар сонгосон боловч ЭМЯ-с бусад гишүүнийг томилоогүйгээс ТУЗ-ийн гишүүд бүрэн бүрэлдээгүй байна. ТУЗ байгуулаагүй байгаа нь дотоод хяналтын тогтолцоо алдагдах эрсдэлтэй байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ", Эрүүл мэндийн сайдын 2020 оны 11 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх заавар"-ын 1-т Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-д эмнэлгийн засаглах эрхийг шилжүүлэх замаар шийдвэр гаргалт, тусламж үйлчилгээнд тавих хяналт, үйл ажиллагааны зохицуулалтад өмчлөгч болон санхүүжүүлэгч байгууллага, эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдийн төлөөллийг оролцох боломжийг бүрдүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг сонгоогүй байгаа, ТУЗ-ийн чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. УХТЭ-ийн захирлын 2023 оны 12-р сарын 25-ны өдрийн А/146 тоот тушаалаар ЭМЯ-с шилжүүлсэн хугацаа дуусах дөхсөн 665,459.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг актлах тушаал гаргасан, устгалд оруулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" заалтууд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 388

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

дугаар тушаалтай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн яамны холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг арилгах, албан шаардлага хүргүүлэх

3. Тайлант онд хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материал, сэлбэг хэрэгсэл зэрэг нийт 309,958.5 мянган төгрөгийн шууд худалдан авалтаар худалдан авсан, өмнөх оны аудитаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.” заалт, Засгийн газрын 2021 оны 24 дүгээр тогтоолтой нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сонгон шалгаруулалтгүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг арилгаж, холбогдох албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх

4. ЭМДЕГ-ын чанарын болон төлбөрийн хяналтаар тус эмнэлгийн баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс /эмчийн болон байцаагчийн хасагдал/ шалтгаалан ЭМДС-аас гүйцэтгэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсний төлбөрт 38,639,523.8 мянган төгрөгийг нэхэмжилсэн дүнгээс 2,917,607.4 мянган төгрөг мянган төгрөг буюу 7.5 хувийн санхүүжилт хасагдсан байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй:”, 13.1.1 “даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх;” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын сангаас авах эмнэлгийн тусламжийн үйлчилгээний санхүүжилтийн нэхэмжлэхийн бүрдүүлэлт, шалгуурт тавих хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төсөв, төсвийн хуваарьтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант оны үйл ажиллагааны нийт орлого, зардлыг 44,549,992.1 мянган төгрөгөөр төлөвлөн, төсвийн хуваарийг батлуулсан бөгөөд тайлант оны дундуур өөрчлөлт орсон эсэх нь тодорхойгүй, холбогдох баримтыг ирүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, 16.5.6 “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Эрх бүхий албан тушаалтнаар төсвийн хуваарийг батлуулж, орлогыг бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах

Бараа материалын үлдэгдэл нөөцтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Бараа материалын үлдэгдэлд 69,208.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий тоо ширхэг олон, өртөг өндөр эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц байна, мөн 2023 оны 3 дугаар сард хэрэглэх хугацаа дууссан 24,000 ширхэг “Натри хлорид 0.9%-10мл” уусмалыг ХӨСҮТ-өөс авсан байна. Тухайлбал, Паклитаксел 300мг/50мл 56,740.0 мянган төгрөгийн 184 ширхэг, Арбидол 100мг

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2,445.0 мянган төгрөгийн 2344 ширхэг, Флурурацил 500мг 12,468.0 мянган төгрөгийн 856 ширхэг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;" 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" заалт, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах тухай" журмын 2.2 "Эмнэлгийн эмийн сан уг жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг тогтмол байлгаж, хүчинтэй хугацаанд байнга хяналт тавин нөхөн сэлбэж хадгална. Нөөцийн бүрдүүлэлт, нөхөн сэлбэлтэд эмнэлгийн эмэн эмчилгээний хороо сар бүх хяналт тавина" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын хэрэгцээг оновчтой тодорхойлж, үргүй зардал гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БҮРҮҮ ИЛЭРХИЙЛИЙН НЭГТЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдэлнийг тусгахгүй орхигдуулсан		Бүрүү тусгах илэрхийлсэн		Үүсгэл			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн өмнөх оны цэвэр хөрөнгө өмчийн дүн 68,479,624.5 мянган төгрөг байхад Өмчийн өөрчлөлтийн тайланд 133,021,521.3 мянган төгрөгөөр буюу 64,541,896.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	64,541,896.8			1	64,541,896.8	1	64,541,896.8		
Санхүүгийн байдлын тайлангийн тусгай зориулалттай материал дансны тайлант оны 73,837.4 мянган төгрөгийн үлдэгдлийг бараа материалын тайлангийн 395,120.0 мянган төгрөгийн үлдэгдлээс 321,262.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	321,282.6			1	321,282.6	1	321,282.6		
Дүн	2	64,863,179.4	-	-	2	64,863,179.4	2	64,863,179.4	-	-

СНАГ-2024/18/НА-СТА-ТШЗ

Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

үйлчилгээ үзүүлсний төлбөрт 38,639,523.8 мянган төгрөгийг нэхэмжилсэн дүнгээс 2,917,607.4 мянган төгрөг мянган төгрөг буюу 7.5 хувийн санхүүжилт хасагдсан байна.

УХТЗ-ийн захирлын 2023 оны 12-р сарын 25-ны өдрийн А/146 тоот тушаалаар ЭМЯ-с шилжүүлсэн хугацаа дуусах дөхсөн 665,459.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг актах тушаал гаргасан, устгалд оруулаагүй байна.

Тайлант онд хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материал, сэлбэг хэрэгсэл зэрэг нийт 309,958.5 мянган төгрөгийн шууд худалдан авалтаар худалдан авсан, өмнөх оны аудитаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Илчилгээ үзүүлсний төлбөрт 38,639,523.8 мянган төгрөгийг нэхэмжилсэн дүнгээс 2,917,607.4 мянган төгрөг мянган төгрөг буюу 7.5 хувийн санхүүжилт хасагдсан байна.										
УХТЭ-ийн захирлын 2023 оны 12-р сарын 25-ны өдрийн А/146 тоот тушаалаар ЭМБ-с шилжүүлсэн хугацаа дуусах дөхсөн 665,459.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг актаах тушаал гаргасан, устгалд оруулаагүй байна.	1	665,459.1		1	665,459.1					
Тайлант онд хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материал, сэлбэг хэрэгсэл зэрэг нийт 309,958.5 мянган төгрөгийн шууд худалдан авалтаар худалдан авсан, өмнөх оны аудитаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	309,958.5					1	309,958.5		
Дүн	6	1,198,097.8	-	3	675,417.6	2	222,680.2	1	309,958.5	-

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга		Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
				Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 287 зардлын гүйлгээний 9,296,918.4 мянган төгрөгийн мэдээлэл байршуулахаас 1,131,607.0 мянган төгрөгийн зарлагын 10 гүйлгээ, худалдан авах ажиллагааны өөрчлөлт орсон төлөвлөгөө зэргийг мэдээлээгүй, мөн шилэн дансны “хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн мэдээлэл” хэсэгт мэдээлэгдэх зарим тендерүүдийн мэдээллийг мэдээлээгүй байна. Тухайлбал: Санчир ундрах ХХК (Багц 44,45,47,48,57,62,67) гэрээний нийт дүн 1,499,040.0 мянган төгрөг, Чоно гол ХХК (Багц 23,39,40,46,49,50,51,52,65,66) гэрээний нийт дүн 1,499,910.5 мянган төгрөг байна.		1	4,130,557.5					1	4,130,557.5
Дүн		1	4,130,557.5	-	-	1	4,130,557.5	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Тайлант онд 1,113,094.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг шууд худалдан авах гэрээ байгуулж худалдан авсан, гэрээг тасаг нэгжийн ажилтнууд бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулдаг ба гэрээ дүгнэсэн акт байхгүй байна		1	1,113,094.1					1	1,113,094.1
Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендэрт оролцогч байгууллагын зүгээс ирүүлсэн бараа бүтээгдэхүүний дээжийг холбогдох тасаг, нэгжээр чанарын хяналт хийлгүүлж авсан дүгнэлтийг гарын үсгээр баталгаажуулаагүй байна.		1	-					1	-
Тайлант онд зохион байгуулсан 149,950 мянган төгрөгийн өртөгтэй харуул хамгаалалтын үйлчилгээ болон 145,037.7 мянган төгрөгийн нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг тусгасан боловч шалгарсан ТДЕ ХХК, Өлзийтхан ХХК-аас гүйцэтгэлийн баталгаа авахгүйгээр байгуулсан байна.		1	294,987.7					1	294,987.7
Дүн		3	1,408,801.8	-	-	3	1,408,801.8	-	-
Нийт дүн		4	5,538,639.6	-	-	4	5,538,639.6	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 307/АД150055
СНАГ-2024/18/КА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд тус эмнэлгийн хамт олны төлөөлөх 3 гишүүнийг Ерөнхий захирлын 2021 оны А/100 тоот тушаалаар "Ажлын хэсэг байгуулах тухай" хурлаа хийж 3 гишүүнийг сонгосон боловч Эрүүл мэндийн яамнаас бусад гишүүнийг томилоогүйгээс Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд бүрэн бүрэлдээгүй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн байгуулаагүй байгаа нь дотоод хяналтын тогтолцоо алдагдах эрсдэлтэй байна

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 зүйлийн 17.4-т "Төрийн болон орон нутгийн өмчит мэргэжлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага", Эрүүл мэндийн сайдын 2020 оны 11 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх заавар"-ын 1-т Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-д эмнэлгийн засаглах эрхийг шилжүүлэх замаар шийдвэр гаргалт, тусламж үйлчилгээнд тавих хяналт, үйл ажиллагааны зохицуулалтад өмчлөгч болон санхүүжүүлэгч байгууллага, эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдийн төлөөллийг оролцох боломжийг бүрдүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг бүрэн томилоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Э. Албан шаардлага 2024.02.23 СНАГ-001 Doc.1

0001962771



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23

№ 308/A0150 055

Улаанбаатар хот

СНАГ-2024/18/НА СГА-ТЦЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 1,113,094,100.00 /нэг тэрбум нэг зуун арван гурван сая ерэн дөрвөн мянга нэг зуун/ төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг шууд худалдан авах гэрээ байгуулж худалдан авсан, гэрээг тасаг нэгжийн ажилтнууд нийлүүлэгчтэй байгуулдаг, гэрээ дүгнэсэн актад ерөнхий нягтлан бодогч, санхүүгийн ажилтнаар гарын үсэг зуруулаагүй, гэрээ дүгнэсэн акт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4.Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.", Засгийн газрын 2021 оны 24 дүгээр тогтоолд" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9.-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа босго үнийг баримтлалгүй шууд гэрээ байгуулсан, хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тухай гэрээг тасаг нэгжийн ажилтнууд байгуулсан, гэрээ болон гэрээ дүгнэсэн актад ерөнхий нягтлан бодогч, санхүүгийн ажилтнаар гарын үсэг зуруулаагүй, гэрээ дүгнэсэн актгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал /Б Бямбадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б Оюундарь/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц НАРАНЧИМЭГ
Ц ХОСЖАРГАЛ

Д ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

2. Албан Шаардлага 2024.02.23 SN-EG-00 Doc1

0001062763



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 309/А0150055
СНАГ-2024/18/КА-СГА-ТЧУЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерт оролцогч байгууллагын зүгээс ирүүлсэн бараа бүтээгдэхүүний дээжийг холбогдох тасаг, нэгжээр чанарын хяналт хийлгүүлж авсан дүгнэлтийг гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2-т "үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерт оролцогч байгууллагын зүгээс ирүүлсэн бараа бүтээгдэхүүний дээжийг холбогдох тасаг, нэгжээр чанарын хяналт хийлгүүлэн авсан дүгнэлтийг гарын үсгээр баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал /Б Бямбадорж /, ерөнхий нягтлан бодогч /Б Оюундары/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Д.ЭХБАЯР

0001060765



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын

23

№ 310/АД/2024/055

Улаанбаатар хот

СНАГ-2024/18/КА-СГА-Тш

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд гэрээ байгуулсан 149,950,000.00 /нэг зуун дөчин есөн мянга есөн зуун тавин мянган/ төгрөгийн өртөгтэй харуул хамгаалалтын үйлчилгээ, мөн 145,037,700.00 /нэг зуун дөчин таван сая гучин долоон мянга долоон зуун/ төгрөгийн Нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг тусгасан боловч шалгарсан ТДЕ ХХК, Өлзийтхан ХХК-аас гүйцэтгэлийн баталгаа авахгүйгээр гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4 "Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана.", 43.4.2. "100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9.-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант онд зохион байгуулсан сонгон шалгаруулалтын "тендерийн баримт бичиг"-т гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг шаардсан боловч шалгарсан компаниудаас гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал /Б. Бямбадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б. Оюундарь/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц НАРАНЧИМЭГ
Ц ХОСЖАРГАЛ

Д ЭХБАЯР

0001260767



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23

№ 311/A0750 D55

Улаанбаатар хот

СНАГ-2024/18/КА-СТА-ТМЦ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материал, сэлбэг хэрэгсэл зэрэг нийт 309,958,500.00 /гурван зуун есөн сая есөн зуун тавин найман мянга таван зуун/ төгрөгийн шууд худалдан авалтаар худалдан авсан, өмнөх оны аудитаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4 Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаартай тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, ... залруулах ажлыг зохион байгуулсан байна"-д 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" ... гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материал, сэлбэг хэрэгсэлийг шууд худалдан авалтаар худалдан авсан, өмнөх оны аудитаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зэрэгт төлөвлөлт, эдийн засаг, маркетинг хариуцсан дэд захирал Э Анхбаярт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал /Б.Бямбадорж/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

Д.ЭХБАЯР

0001060769



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024

02

23

№ 312/A0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/18/КА-СТА-ТНЦ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирлын 2023 оны А/146 тоот тушаалаар Эрүүл мэндийн яамнаас шилжүүлсэн хугацаа дуусах дөхсөн 665,459,156.00 /зургаан зуун жаран таван сая дөрвөн зуун тавин есөн мянга нэг зуун тавин зургаан/ төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг актлах тушаал гаргасан, устгалд оруулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", заалтууд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах тухай" журмын 2.2-т "Эмнэлгийн эмийн сан уг жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг тогтмол байлгаж, хүчинтэй хугацаанд байнга хяналт тавин нөхөн сэлбэж хадгална. Нөөцийн бүрдүүлэлт, нөхөн сэлбэлтэд эмнэлгийн эм, эмчилгээний хороо сар бүх хяналт тавина" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Хэрэгцээ, шаардлагыг үндэслэлгүй нөөц үүсгэсэн эм, эмнэлгийн хэрэгсэл болон хугацаа дуусах дөхсөн эм, эмнэлгийн хэрэгслийг харьяа байгууллагуудад нийлүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын дарга А Өнөржаргал, эм, эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмж хариуцсан ахлах шинжээч Ч Амаржаргал, лабораторийн чанар аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ийн

ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Баха тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

А. Албан шаардлага 2024-02-23 АНХ-18/1000

0001060775



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024

оны

02

дугаар сарын

23

№

313/АД 150 055

Улаанбаатар хот

СНАГ-2024/18/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 287 зардлын гүйлгээний 9,296,918,400.00 /есөн тэрбум хоёр ерэн зургаан сая есөн зуун арван найман мянга дөрвөн зуун/ төгрөгийн мэдээлэл байршуулахаас 1,131,607,000.00 /нэг тэрбум нэг зуун гучин нэгэн сая зургаан зуун долоон мянган/ төгрөгийн зардлын ажил гүйлгээний 10 мэдээлэл, худалдан авах ажиллагааны өөрчлөлт орсон төлөвлөгөө зэргийг мэдээлээгүй, мөн шилэн дансны "хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн мэдээлэл" хэсэгт мэдээлэгдэх зарим тендерүүдийн /нийт 4,130,557,500.00 дөрвөн тэрбум нэг зуун гучин сая таван зуун тавин долоон мянга таван зуун төгрөгийн/ мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," заалтууд, болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр 328 "хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь мэдээлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал /Б.Бямбадорж/, ерөнхий нягтлан бодогч /Б.Оюундарь/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Ажлал 51-264230

Э. Алтан Шувуу-дугаа 2024.02.23 /МОН-9913001/

0001062776



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 314/AO/SD 055
СОЛГ-2024/118/КА-СТА-Тел3

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын чанарын болон төлбөрийн хяналтаар тус эмнэлгийн баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс /эмчийн болон байцаагчийн хасагдал/ шалтгаалан Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсний төлбөрт 38,639,523,800.00 /гучин найман тэрбум зургаан зуун гучин есөн сая таван зуун хорин гурван мянга найман зуун/ төгрөгийг нэхэмжилсэн дүнгээс 2,917,607,400.00 /хоёр тэрбум есөн зуун арван долоон сая зургаан зуун долоон мянга дөрвөн зуун/ төгрөг буюу 7.5 хувийн санхүүжилт хасагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.5 "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх", Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй", 13.1.1 "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн даатгалын сангаас авах эмнэлгийн тусламжийн үйлчилгээний санхүүжилтийн нэхэмжлэхийн бүрдүүлэлт, шалгуурт тавих хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал /Б.Бямбадорж /, ерөнхий нягтлан бодогч /Б.Оюундарь/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц НАРАНЧИМЭГ
Ц ХОСЖАРГАЛ

Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тогруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Э. Албан Шаардлага 2024.0223.БНБГ.АА (Х.х.)

0001969779

[illegible]

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг